

“ОРХОН ЖИМС НОГОО” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2010.02.25

“Орхон Жимс Ногоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хуралдааны дэг.

Хурлыг “Орхон Жимс Ногоо” Хувьцаат компаний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2010 оны 02 сарын 25-ний өдрийн 12 цагт Дархан-Уул аймгийн Орхон суманд хуралдав.

Хэлэлцэх асуудал:

- Компанийн жилийн санхүүгийн тайлан. аудиторын дүгнэлт
- ТУЗ-н гишүүдэд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга, ТУЗ-н дарга сонгох
- Нэгдмэл сонирхолтой этгээдүүд тэдний эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардал, цалин
- Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
- Компанийн хяналтын зөвлөлийн тайлан
- Компаний үйл ажиллагааг сэргээн, оруулах хөрөнгө оруулалтын асуудал төслийн талаар
- Арилжааг сэргээх
- Тусгаарлагдсан хувьцааг чөлөөлөх
- Бусад асуудлуудыг
- Санал шүүмжлэл. / Цаг тогтоохгүй/
- Зохион байгуулалтын асуудал хэлэлцэх. / Цаг тогтоохгүй/
- Хурлыг 12 цагт эхлэн өдөрт нь багтааж дуусгана.

“Орхон Жимс Ногоо” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлаар хэлэлцэх асуудал

2010.02.25

Орхон сум

- Компанийн жилийн санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлт
- ТУЗ-н гишүүдэд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга, ТУЗ-н дарга сонгох
- Нэгдмэл сонирхолтой этгээдүүд тэдний эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардал, цалин
- Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
- Компанийн хяналтын зөвлөлийн тайлан
- Компаний үйл ажиллагааг сэргээн, оруулах хөрөнгө оруулалтын асуудал төслийн талаар
- Арилжааг сэргээх
- Тусгаарлагдсан хувьцааг чөлөөлөх
- Бусад асуудлууд

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц

Хувьцаа эзэмшигч	Регистрийн дугаар	Хувьцааны тоо
1. Б.Сүхбаатар	ЧЕ 58021610	25083
2. С.Баасанхүү	ЧР 60040364	40391
3. Т.Одсүрэн	ЧР 83091860	23230
4. Chung Si Woo	КО 57012650	136682
5. Jung Heejeen	КО 7910306F	34470
6. А.Ганбат	ТЛ 62021571	963
7. Д.Эрдэнэчимэг	ХН 56070262	20964
8. У.Дэлгэрмаа	ХП 71110361	10575

Нийт: 292358 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 71,2%-ийн ирцтэй

**“Орхон Жимс Ногоо” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн
хурлын протокол**

2010.02.25

Орхон сум

“Орхон Жимс Ногоо” Хувьцаат компаний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2010 оны 02 сарын 25-ний өдрийн 12 цагт Дархан-Уул аймгийн Орхон суманд хийв.

Хуралд 71,2 хувийн хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцон хурлыг ТУЗ-ийн дарга Б.Сүхбаатар нээн үг хэлэв.

Б.Сүхбаатар:

- Өнөөдөр “Орхон Жимс Ногоо” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хууль дүрмийн дагуу хурлыг хийх болсон.

“Орхон Жимс Ногоо” ХК-ний гүйцэтгэх захирал Ж.Сандуйжав үйлдвэрлэлийн талаар товч танилцуулав.

Ж.Сандуйжав:

- Санхүүгийн жилийн хувьд ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй тул Х тайлан гарсан. Цаашид төсөл хэрэгжүүлэх зээлийн асуудлыг шийдэх хүртэлх хугацааны асуудлыг шийдэж өгөх шаардлагатай байна.
- Үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүдээс цаашид ашиглаж болох, төхөөрөмжүүд агуулахад оруулах, хэрэглэгдэхгүй болсон тоног төхөөрөмжийг актлах зэрэг арга хэмжээ авах мөн цаашид энэ объект барилга байгууламжийг засаж ямар үйлдвэрлэл явуулж болох талаар судлах.
- Хөрөнгө оруулалтын асуудлаар тодорхой тооцоо судалгаа, төсөл хийж хэрэгжүүлэх асуудал дээр хувьцаат компаний удирдлага дийлэнх, олонхи хувьцаа эзэмшиж буй хүмүүс шийдвэртэй арга хэмжээ авч ажилламаар байна.
- Орон нутгийн төр захиргаа, татварын байгууллага урьд үүссэн өр төлбөрөө нэхэхээс өөр туслалцаа үзүүлэхгүй.

Баасанхүү:

- Хөрөнгийн эх үүсвэр олж үйлдвэрийн барилга байшинд эхний ээлжинд засвар хийж ашиглаж болох, эхний ээлжинд юу хийж болох талаар тооцоо хийх, газар авч орон нутгаас өөрөө өөрийгөө хангаж ажиллах тал дээр анхаарах, орон нутгийн засаг захиргаанд саналаа гаргаж өгөх хэрэгтэй.

Д. Эрдэнэчимэг:

- Үйлдвэрлэлийг шинэчлэх, гадаад дотоодын зээл төсөлд хамруулж яаралтай ажилд оруулан ногоо боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл оруулж ирэх, импортын бүтээгдэхүүнийг дотоодын сайн чанарын хямд үнэтэй бүтээгдэхүүнээр орлуулахад төсөл хийж холбогдох яаманд хандах нь зүйтэй
- Эхний ээлжинд засвар, энэ тавигдаж байгаа асуудлыг шийдэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хурлаас тогтоох нь

1. ТУЗ-ийн дарга болон гишүүд гүйцэтгэх удирдлагыг хуучин хэвээр нь байлгах.
2. Хувьцааны арилжааг сэргээж тусгаарлагдсан хувьцааг чөлөөлөх арга хэмжээ авах
3. Компаний үйл ажиллагааг цаашид эрчимтэй сэргээх арга хэмжээ авах аар хуурлаас шийдвэрлэв.

Протокол хөтөлсөн


А.Ганбат

Маягт ТТ-02

Үндэсний татварын алба

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тайлан

1. ТТД: 2050242 2. Нэр: "Орхон Нише Ногоо" ХК

3. Татвар төлөгчийн одоогийн хаяг:

Аймаг, хот: Дархан-Уул Утас1: _____ Утас 2: _____
 Сум, дүүрэг: Орхон сум Факс: _____
 Баг, хороо: _____ Шуудангийн хайрцаг No.: _____
 Гудамж, хороолол: _____ E-mail хаяг: _____
 Байшин: _____
 Хашаа, хаалга: _____

4. Эрхлэх үйл ажиллагаа: _____ Үндсэн: _____ - аучисийн үйлдвэр

5. Тайлант хугацаа: он 2009 улирал 4

Тухайн тайлангийн хугацаанд үйлдвэрлэл явуулж, борлуулалт хийгээгүй бол (х)- ээр тэмдэглэнэ

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд		Мөр	Т.г-ийн тодорхойлсон	Тат.алба хянасан
1. Шаталсан хувиар татвар ногдох орлогын нийт дүн (мөр 2+3+...+14)		1	<u>2</u>	
Үүнээс	Үндсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний орлого	2		
	Туслах үйлдвэрлэл, ажил үйлчилгээний орлого	3		
	Зээлийн үйл ажиллагааны орлого	4		
	Даатгалын үйл ажиллагааны орлого	5		
	Бирж, брокерийн үйл ажиллагааны орлого	6		
	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны орлого	7		
	Хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	8		
	Зээллэгийн хүүгийн орлого	9		
	Хөрөнгө түрээслүүлсний орлого	10		
	Зуучлах үйл ажиллагааны орлого	11		
	Бусдаас худалдаж авсан хувьцааг борлуулсны орлого	12		
	Гадаад валютын арилжаанаас олох орлого	13		
	Албан татвар ногдох бусад орлого	14		
	2. Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн (мөр 16+17+... +21)		15	<u>2</u>
Үүнээс	Засгийн газрын зээллэгийн хүүгийн орлого	16		
	Донорын цус, цусан бүт-н, эд, эрхтэнийг эмчилгээнд хэрэглэснээс олсон орлого	17		
	Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлого	18		
	Төрийн бус байгууллагын гишүүд дэмжигчдийн татвар, хандив	19		
	Олон улсын, улсын, орон нутгийн чанартай автозам, замын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах, засвар, арчлалт хийхэд зарцуулсан хөрөнгө	20		
	Гадаадын хөрөнгө оруулагч өөрт ногдох орлогоос тухайн аж ахуйн нэгжид дахин оруулсан хөрөнгө оруулалт	21		
3. Татвар ногдох орлогоос хасагдах зардлын дүн (мөр 23+24+... + 49)		22	<u>2</u>	
Үүнээс	Цалин, хөдөлмөрийн хөлс	23		
	Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	24		
	Түүхий эд, үндсэн болон туслах материал, хагас боловсруулсан зүйл	25		
	Эргэлтийн бус сав баглаа боодлын зардал	26		
	Цахилгаан эрчим хүч, дулаан, уур ус	27		
	Бараа, материалын хэвийн хорогдол	28		
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслэл	29		
	Бүх төрлийн шагнал, урамшуулал, тэтгэмж, бусдад өгсөн хандив, бэлэг дурсгал, хүлээн авалт, хэвлэл захиалгын зардал	30		
	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл	31		
	Их болон урсгал засварын зардал	32		
	Бүх төрлийн торгууль ба татвар төлөгчийн буруугаас бусдад учруулсан хохирлыг нөхсөн төлөөс	33		
	Гадаад валютын арилжаанаас хүлээсэн бодит алдагдал	34		
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс	35		
	Түрээсийн төлбөр	36		
	Зээлийн хүүгийн зардал	37		
	Захиргааны зардал	38		
	Төсөвт төлсөн АТБӨЯТХ-ийн албан татвар	39		
	Төсөвт төлсөн газар, байгалийн нөөц ашигласны төлбөр хураамж	40		
	Төсөвт төлсөн онцгой албан татвар	41		



Үндэсний татварын алба

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайлан

1. Тайлангийн хугацаа: 2009 ас
 2. ТТД: 2050241111
 3. Татвар төлөгчийн нэр: Архан АНХ
 4. Татвар төлөгчийн хаяг:
 Аймаг, дүүрэг: Вархан-уул
 Сум, хороо: Архан
 Гудамж, хорооллын нэр: Б.О. 805
 Гудамж, байшингийн дугаар:
 Хашаа, хаалганы дугаар:

Зөвхөн татварын албан ажлын хэрэгцээнд
 БТД:
 Татварын алба:
 Хүлээн авсан он, сар, өдөр: _____

Утас: _____
 Факс: _____
 Шуудангийн хайрцаг No: _____

А. Өмнөх тайлангийн үлдэгдэл

(мянган төгрөг)

Урьд тайлангийн илүү төлөлт	5	Урьд тайлангийн дутуу төлөлт	6
Хаалтын бичилт			
Буцаан олголт	7	Бусад татварын илүү төлөлтөөс	8
Бусад татварын дутуу төлөлтөнд суутгасан	9		
Үлдэгдэл /илүү/ (5-7-9)	10	Үлдэгдэл /дутуу/ (6-8)	11

Б. Төлбөл зохих албан татварын тооцоо

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд		Мөр	Дүн
Албан татвар ногдуулах эд хөрөнгийн үнэлгээ	Тайлант жилийн 1/15-нд байгаа (V багана, 29-р мөрийн дүн)	12	638500.0
	Тайлант жилд нэмэгдсэн (VII багана, 29-р мөрийн дүн)	13	-
	Тайлант жилд хасагдсан (IX багана, 29-р мөрийн дүн)	14	-
	Дүн (12+13-14)	15	638500.0
Ногдуулсан албан татвар	Тайлант жилийн 1/15-нд байгаа хөрөнгөд (12*0.6%)	16	3831.0
	Тайлант жилд нэмэгдсэн хөрөнгөд ногдох татвар	17	-
	Тайлант жилд хасагдсан хөрөнгийн үлдэх хугацаанд ногдох татвар	18	-
	Дүн (16+17-18)	19	3831.0
Төлбөл зохих албан татвар (11+19-10)		20	3831.0
Тайлангийн хугацаанд төлсөн албан татвар		21	-
Бусад албан татвараас шилжүүлэн тооцсон		22	
Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл (20-21-22)	Илүү (-)	23	
	Дутуу (+)	24	3831.0

В. Тайлант жилд албан татвар ногдуулах үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн товчоо

(мянган төгрөг)

Зориулалт	Бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө		Тайлант жилийн 1/15-ны дүн		Тайлант жилд гарсан тоо хэмжээний өөрчлөлт				Тайлант жилд албан татвар ногдуулах дүн	
	Нэр төрөл	Мөр	Тоо	Үнэлгээ	Нэмэгдсэн		Хасагдсан		тоо	Үнэлгээ
					VI	VII	VIII	IX		
I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI
Үйлдвэрлэл, үйлчилгээний	Байшин, барилга	25	6	638500.0					6	638500.0
	Байгууламж	26								
	Орон сууц	27								
	Бусад	28								
	Дүн	29	6	638500.0					6	638500.0
Хувийн орон сууц	Орон сууц	30								
Нийтийн эзэмшлийн барилга байгууламж	Байшин, барилга	31								
	Байгууламж	32								
НИЙТ ДҮН		33	6	638500.0					6	638500.0

МаягТТ-20

Үндэсний Татварын Алба



Газрын төлбөрийн тайлан

Зөвхөн татварын албаны ажлын хэрэгцээнд
БТД
Татварын алба
Хүлээн авсан он,сар,өдөр -- . -- . --

ТТД 12015021421

Нэр _____

Тайлангийн 2010 04

Үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээний тайлан

С | | | | | | | | | |

\ мянган төгрөгөөр \

№	Үзүүлэлт	Хэмжээ га
1	Төлбөрт хамрагдах нийт газрын хэмжээ	4.28
2	Төлбөрт ногдуулах газрын хэмжээ	4.28
3	Төлбөрөөс чөлөөлөгдөх газрын хэмжээ	-
4	Төлбөрт ногдуулсан газрын зориулалт, хэмжээ, үүнээс	-
4.1	Иргэний ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа	Бэлчээрийн
		Тариалангийн
		Хадлангийн
4.2	Аж ахуйн нэгжийн үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашиглагдаж байгаа	Бэлчээрийн
		Тариалангийн
		Хадлангийн
4.3	Төрийн болон төсвийн байгууллагын эзэмшилд	
4.4	Хот нийтийн үйлчилгээний зориулалтаар	
4.5	Худалдаа үйлчилгээний зориулалтаар	
4.6	Нөөцийг нь ашиглах зориулалтаар	
4.7	Бусад	

	Дебет	Кредит
5 Ногдуулсан газрын төлбөр		102.7
6 Хөнгөлсөн газрын төлбөр		
7 Тайлангийн хугацаанд төсөвт шилжүүлсэн	-	
8 Урьд оны эцсийн илүү, дутуу		
9 Эцсийн тооцоогоор илүү, дутуу		102.7
10 Тайлан хожимдуулсны торгууль		-
11 Нийт төсөвт төлбөл зохих \ 9 Кр + 10 Кр \		102.7

Тайланг гаргасан сум, дүүргээс томилогдсон ажилтан \

Тайланг хүлээн авсан татварын улсын байцаагч



19... оны ... сарын ... өдөр
2010 1 19.

[Signature] Б.Тануур. \

**“Орхон жимс ногоо” ХК-ийн
хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын зар**

“Орхон жимс ногоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2010 оны хоёрдугаар сарын 25-ны 12.00 цагт Дархан-Уул аймгийн Орхон суман дахь компанийн байранд болно. Хурлаар:

- Компанийн санхүүгийн жилийн тайлан аудиторын дүгнэлт
- ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга. ТУЗ-ийн дарга сонгох
- Нэгдмэл сонирхолтой этгээдүүд тэдний эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардал цалин
- Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
- Компанийн хяналтын зөвлөлийн тайлан
- Компанийн үйл ажиллагааг сэргээн, оруулах хөрөнгө оруулалт, төслийн талаар
- Арилжааг сэргээх
- Тусгаарлагдсан хувьцааг чөлөөлөх
- Бусад асуудлуудыг хэлэлцэнэ.

Бүртгэх өдрийг 2010 оны нэгдүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгох бөгөөд хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй компанийн төв байр болон Орхон суман дахь компанийн байранд ажлын өдрүүдийн 10.00-17.00 цагийн хооронд танилцаж болно.

ТУЗ, Хурал зохион байгуулах комисс
Холбоо барих утас: 77-458272, 99095535, 5525-0044

E-Mail: alsintuv@yahoo.com

**“ОРХОН ЖИМС НОГОО” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

“Орхон жимс ногоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2010 оны хоёрдугаар сарын 25-ны 12.00 цагт Дархан-Уул аймгийн Орхон суман дахь компанийн байранд болно. Хурлаар:

-Компанийн санхүүгийн жилийн тайлан, аудиторын дүгнэлт

-ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга ТУЗ-ийн дарга сонгох

-Нэгдмэл сонирхолтой этгээдүүд тэдний эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо

-ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин

-Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан

-Компанийн хяналтын зөвлөлийн тайлан

-Компанийн үйл ажиллагааг сэргээн, оруулах хөрөнгө оруулалт төслийн талаар

-Арилжааг сэргээх

-Тусгаарлагдсан хувьцааг чөлөөлөх

-Бусад асуудлуудыг хэлэлцэнэ.

Бүртгэх өдрийг 2010 оны нэгдүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгох бөгөөд хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй компанийн төв байр болон Орхон суман дахь компанийн байранд ажлын өдрүүдийн 10-17 цагийн хооронд танилцаж болно.

ТУЗ, хурал зохион байгуулах комисс
Холбоо барих утас: 77-458272, 99095535, 5525-0044

E-mail: alsiintuv@yahoo.com



Б.СҮХБААТАР
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

“Орхон жимс ногоо” хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах журам

- 1.1 ХНХ-ын ажиллах хэлбэр нь хуралдаан байх бөгөөд эрх хэмжээнийхээ асуудлуудыг хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 1.2 ХНХ ын ээлжит хурлыг хагас жил тутам нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна. Хувь нийлүүлэгчдийн дийлэнх олонхийн ирцтэй тохиолдолд хурал хүчин төгөлдөр байна.
ХНХ ын зарыг хүргэхдээ хувь нийлүүлэгчийн хуралд оролцох боломжийг олгосон байна. Энэхүү зарчмыг дараах нөхцлийг бүрдүүлэх замаар хангана.
 - a/ ХНХ ын тов болон хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг хувь нийлүүлэгчдэд хуралд бэлтгэх боломж олгон 30 аас доошгүй хоногийн өмнө баталгаат шуудан болон факс, электрон шуудан, мэдээллийн хэрэгсэлээр хүргэнэ
 - b/ Хувьцаа эзэмшигчдэд хүргэх ХНХ ын зард тухайн хувьцаа эзэмшигч хуралд оролцох хэлбэрээ сонгоход шаардлагатай мэдээллийг агуулсан байна.
 - c/ Хуралд оролцох хувь нийлүүлэгчдэд заавал танилцуулах шаардлагатай мэдээллийг электрон шуудан, захидал, биечлэн хүргэх гэх мэт тогтмол хүргэж заншсан байна
- 1.3 Ээлжит хурлыг хувь нийлүүлэгчдийг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.
- 1.4 ХНХ ын ээлжит бус хурлыг хувь нийлүүлэгчид болон тус зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно
- 1.5 ХНХ -д оролцох эрх бүхий гишүүдийн нэрсийн жагсаалттай төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон бусад гишүүд танилцах эрхтэй байна.
- 1.6 ХНХ-д аливаа асуудалыг шийдвэрлэхэд гишүүд бүр санал өгөх бүрэн эрхтэй байна.
- 1.7 Хурлаар хэлэлцэж буй асуудлын талаар гишүүдийн санал тэнцвэл уг хурлыг удирдаж буй төлөөлөн удирдах зөвлөлийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 1.8 Хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг батлагдсан дараалалын дагуу нэг асуудлыг хэлэлцэж дууссаны эцэст дараагийн асуудлыг хэлэлцэнэ.

- 1.9 ХНХ-ыг удирдах зөвлөлийн дарга, түүнийг эзгүйд уг даргыг орлох гишүүн удирдина.
- 1.10 ХНХ-ын нарийн бичгийн дарга хурлын үйл явц,ажилгааны талаар тэмдэглэл хөтлөж, протокол гаргана. Хурлын протоколд дараах зүйлсийг зайлшгүй тусгасан байна.
- а/ ХНХ-ын эхэлсэн болон дууссан он сар өдөр цаг
 - б/ ХНХ-д оролцсон гишүүдийн нэрсийн жагсаалт
 - в/ хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн учир шалтгааны тухай
 - г/ Хурлаар хэлэлцүүлэгдэж буй асуудал,асуудлыг танилцуулагч этгээдийн овог нэр,албан тушаал
 - д/ Хэлэлцэж буй асуудлын талаар гарсан саналууд, санал асуултын дүн
 - е/ ХНХ-ын нийт гишүүдийн саналыг нэгтгэсэн эцсийн шийдвэр
 - ё/ Протоколтой танилцсан гишүүдийн гарын үсэг мөн уг протоколыг хөтөлсөн нарийн бичгийн даргын гарын үсэг
- 1.11 Асуулт хариулт,санал нь зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой товч тодорхой байна.
- 1.12 Хурлаас шийдвэрийг үндэслэн ХНХ-ын тогтоол,хурлын протокол гарна. ХНХ-ын шийдвэр нь тогтоол байна. Уг тогтоолд зөвлөлийн дарга гарын үсэг зурж,тамга дарна.Хурлын протоколд зөвлөлийн дарга нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.Батлагдсан тогтоолыг нарийн бичгийн дарга бүртгэнэ.
- 1.13 Телефон утсаар хуралд оролцох: ХНХ-д 1 ээс дээшгүй гишүүн телефон утас,түүнтэй адилтгах холбооны хэрэгслийн тусламжтайгаар оролцож болно.Гэхдээ хуралд оролцож буй бүх хүмүүс яриаг сонсох,түүнтэй ярих боломжтой байна.Ийм хэлбэрийг хуралд биеэр оролцсонд тооцно. ХНХ-ын гишүүн телефон утсаар хуралд оролцсон тохиолдолд түүний яриа Саналыг дуу бичлэгийн хальсанд буулгаж бэхжүүлэх буюу хурлын тэмдэглэлийг өөрт нь танилуулж гарын үсэг зуруулан баталгаажуулна.
- 1.14 Хувь нийлүүлэгчдийн хурлийн гишүүн биер оролцож чадахгүй тохиолдолд тухайн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлын талаар саналаа асуудал тус бүрээр саналын хуудсанд тодорхой бичиж хурал эхэлхээс өмнө битүүмжилэн ирүүлсэн байх бөгөөд үүнийг тухайн хуралд оролцсонд тооцож, бичгээр ирүүлсэн уг саналыг протоколд хавсаргаж,зохих ёсоор хадгалах үүргийг удирдах зөвлөлийн дарга хүлээнэ.
- 1.15 Уг хурлыг удирдан зохион байгуулж буй удирдах зөвлөлийн гишүүд дээрх журмыг зөрчвөл зохих хууль тогтоомжын дагуу ХНХ эрхийхээ дагуу арга хэмжээ авна.

“Орхон жимс ногоо” хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажилгааны журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь тус компанийн ТУЗ-ийн бүтэц, гишүүдэд тавих шалгуур, түүнчлэн гишүүнийг түр томилох, сонгууль явуулах, нөхөн сонгууль явуулах бүрэн эрх, үүрэг, хурлын дэг журам гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэл зэрэг ТУЗ-н үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 ТУЗ-н үйл ажиллагааны журам нь уг компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжоор тогтоосон дэг журамтай нийцсэн байна.
- 1.3 Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт нь түүний бүрэн эрхийг ТУЗ хэрэгжүүлнэ.
- 1.4 ТУЗ нь жилд хоёроос доошгүй удаа хувь нийлүүлэгчдийн хуралд ажлаа тайлагнана.

Хоёр. “Орхон жимс ногоо” хувьцаат компанийн ТУЗ-н бүтэц болон гишүүдэд тавих шалгуур, сонгууль явуулах

- 2.1 ТУЗ нь хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээр гишүүдийн бүрэн эрхэт хугацаа 4 жил байна. Гишүүнээр сонгогдсон этгээд дараах шалгуурыг хангасан байх ёстой.
 - 2.1.1 Уг компанийн хувь нийлүүлэгч байх
 - 2.1.2 Ял шийтгэлгүй
 - 2.1.3 Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх
 - 2.1.4 Өөр компанийн ТУЗ-д ажилладаггүй байх
- 2.2 ТУЗ-н гишүүдийг хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас сонгоно. Гишүүдийг сонгохдоо хуралд олонхийн саналыг авсан нэр дэвшигчийг сонгно. Уг олонхийн саналыг авсан этгээд ТУЗ-н гишүүнээр сонгогдохоос татгалзвал дараагийн санал авсан хүнийг сонгосонд тооцно.
- 2.3 ТУЗ-н гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон, тус зөвлөлөөс гарсан, тус компанийн хувь нийлүүлэгч биш болсон тохиолдолд хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлаар нөхөн сонгууль явуулна. Нөхөн сонгуулиар гишүүдийг сонгохдоо нэр дэвшигчдээс ихэнхи саналын дийлэнх олонхийг авсан хүнийг сонгоно.
- 2.4 ТУЗ-н гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон эсвэл нас барсан тохиолдолд ТУЗ-н гишүүнийг орлох этгээдийг ТУЗ нөхөн сонгууль явуулах хүртэл түр томилж болно.
- 2.5 ТУЗ-н даргыг ТУЗ-н гишүүд дотроосоо дийлэнх олонхийн саналаар жилээр сонгоно.
- 2.6 ТУЗ-н даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-н даргын томилсон эсвэл ТУЗ-н тухайн удаа сонгосон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

2.7 ТУЗ нь хурлын нарийн бичгийн даргыг томилон ажиллуулна. ТУЗ-н хурлын нарийн бичгийн дарга нь хувь нийлүүлэгчдийн болон ТУЗ-н хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулах, хурлуудын шийдвэрийн бүртгэлийг хөтлөх, биелэлтийг хянах, ТУЗ-н гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах ээлжит болон ээлжит бус хурлын товыг хэлэлцэх асууудлыг ТУЗ-н даргатай зөвшилцөх, хурлын тэмдэглэл хийх зэрэг ажлыг хариуцна.

Гурав. “Орхон жимс ногоо” хувьцаат Компанийн ТУЗ-ийн эрх үүрэг

3.1. ТУЗ нь компанийн үйл ажилагааны стратеги бодлогыг тодорхойлж, уг бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тодорхой болгосон байна. Энэхүү зарчмыг дараах байдлаар хангана.

а/ ТУЗ нь компанийн үйл ажилагааны урт хугацааны бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох бөгөөд тэдгээрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд зах зээлийн нөхцөл байдал, компанийн санхүүгийн чадавхи, бүтээгдэхүүний борлуулалтын түвшин, ажиллах хүчний чадавхи зэрэг олон хүчин зүйлийг тогтмол харгалзан үздэг байх шаардлагатай

б/ ТУЗ нь компанийн үйл ажилагааны бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тул компанийн үйл ажилагааны төлөвлөгөө, төсвийг нэгдсэн журмаар, жилийн хугацаатай батална. Компанийн жилийн үйл ажилагааны төлөвлөгөө, төсөвт компанийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гүйцэтгэх ажил, түүний зардал, уг зардлыг бүрдүүлэх эх үүсвэр зэргийг нарийвчлан тогтоож өгнө.

в/ ТУЗ-өөс нэгдсэн төлөвлөгөө батлахаас гадна үйлдвэрлэлийн үйл ажиллагааны, маркетингийн, хөрөнгө оруулалтын зэрэг нарийвчилсан төлөвлөгөөг баталж болно.

3.2 ТУЗ нь компанийн санхүү, аж ахуйн ажиллагаанд үр дүнтэй хяналтыг дараах зарчимаар хэрэгжүүлнэ.

а/ Компанийн дотоод хяналтын нэгж нь ТУЗ-ийн удирдлагын дор ажиллах замаар компанийн үйл ажилагааны төлөвлөгөөний биелэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн үнэн зөвийг тогтмол хянадаг байх

б/ ТУЗ нь өөрийн чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд эрсдлийн шинжилгээг тогтмол гүйцэтгэдэг байх шаардлагатай байх бөгөөд эрсдлийн үнэлгээ хийх, түүнийг тодорхойлох, эрсдлийн эсрэг авах арга хэмжээг төлөвлөдөг тогтмол бүтэцтэй байна. Ялангуяа хүүгийн эрсдэл, даатгалын эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хууль зүйн эрсдэл, санхүүгийн хэрэгслийн болон эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрээр гарч болох эрсдлийн шинжилгээг тогтмол хийдэг байх.

3.3 ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих замаар удирдлагын үр дүнтэй үйл ажиллагааг хангана. Уг зарчмыг дараах нөхцлөөр бүрдүүлнэ.

а/ Гүйцэтгэх үйл ажиллагааны үр дүнг холбогдох төлөвлөгөөнд үндэслэн хянахаас гадна шаардлагатай үед гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх шийдвэрийг бие даан гаргаж, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэх эрхтэй байна.

б/ Гүйцэтгэх удирдлагын мэдлэг, мэргэжил, чадварт тавигдах шаардлага, гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, урамшууллын журмыг компанийн дүрэмд тухайлан тусгах замаар гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, чадавхийн тогтвортой байдлыг хангаж үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх боломжийг бий болгох нь зүйтэй бөгөөд уг шаардлага гэрээний болон урамшууллын нөхцлийн талаарх саналыг ТУЗ-өөс гаргадаг байх нь зүйтэй.

в/ ТУЗ-ийн гишүүн нь гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг давхар хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг гишүүнийг гүйцэтгэх удирдлагын гэрээтэй холбоотой асуудлаар тухайн гишүүнийг санал хураалтанд оруулахгүй байх замаар сонирхлын зөрчлийг хаасан байна.

3.4. ТУЗ нь хувь эзэмшигчийн эрх, хууль ёсны сонирхлыг хамгаалдаг байна.

а/ ТУЗ нь хувь эзэмшигчдэд компаний үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээллийг хүргэх үүрэг бүхий ажилтантай байх ба хувь эзэмшигчдэд мэдээлэх хүргэх журмыг мөрдүүлж биелэлтэд хяналт тавина.

б/ ТУЗ нь хувь эзэмшигчид болон компанийн бүтэц дэх нэгжүүдийн хооронд эсвэл хувь эзэмшигч хооронд гарч болох маргаан, сонирхлын зөрчлөөс сэргийлэх, гарсан тохиолдолд шийдвэрлэх ажиллагааны журмыг мөрдүүлнэ.

в/ ТУЗ нь удирдлагын зүгээс хувь эзэмшигчдэд мэдээллийг хэрхэн хүргэж байгаад хяналт тавина.

3.5 ТУЗ нь үйл ажиллагааны тодорхой чиглэлээр ТУЗ-д зөвөлгөө үзүүлэх, түүний чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж өгөх зорилго бүхий дагнасан хэсэгтэй байж болно.

Дөрөв. “Орхон жимс ногоо” хувьцаат компанийн мэдээллийн үйл ажиллагааны журам

4. Хувь нийлүүлэгчид болон ТУЗ-д компанийн талаар үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх нь компани болон хувь нийлүүлэгчдийн хоорондын итгэлцлийг хадгалах, нэмэлт хөрөнгө оруулагчдыг бий болгохоос гадна хувь нийлүүлэгчдийн зүгээс компанийн удирдлагад оролцох эрхээ зохистойгоор хэрэгжүүлэх, улмаар компанийн үйл ажиллагааны тогтворжиж, хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр оновчтой гарах үндсийг бүрдүүлнэ. Компани нь хууль зохицуулах байгууллагаас тогтоосон дүрэм журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулахын тулд мэдээллийн үйл ажиллагааны журмыг ТУЗ-өөрөө батлан мөрдүүлдэг байна.

4.1 Мэдээллийг нээлттэй ил тод болгох үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана.

Үүүнд:

а/ Тогтмол байх

- б/ Цаг хугацаандаа байх
 - в/ Компанийн хувь нийлүүлэгчид болон сонирхогч бусад этгээдэд бүгдэд нь тэгш хүртээмжтэй байх
 - г/ Үнэн зөв, тодорхой ойлгомжтой байх
 - д/ Агуулгын хувьд хоёрдмол санаагүй бүрэн дүүрэн байх
 - е/ Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байх
 - ё/ Хувь нийлүүлэгчид мэдвэл зохих өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаахгүй байх
- 4.2 Мэдээллийн үйл ажиллагааны журамд компаниас нийтэд хүргэх мэдээллийн жагсаалт, нийтэд хүргэх арга хэрэгсэл, хариуцах албан тушаалтан зэргийг тогтоосон байна. Нийтэд хүргэх мэдээллийг компанийн веб сайтад байршуулахаас гадна компанийн ажлын байрнаас хэдийд ч саадгүй авах боломжийг хангасан байна. Түүнчлэн хувь нийлүүлэгчдэд зайлшгүй хүргэх мэдээллүүдийг баталгаат шуудан, цахим шуудан, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдэгдэж болно.
- 4.3 Мэдээллийг нээлттэй ил тод болгохдоо ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлага нууц, дотоод мэдээллийг хууль бусаар компанийн ашиг сонирхлын эсрэг ашиглахаас урьдчилан сэргийлж эрхлэн явуулж хяналт тавина.
- 4.4 Хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоогдсон мэдээллээс гадна дор дурдсан мэдээллийг нийтэд хүргэдэг байна.
- а/ ТУЗ-ийн гишүүд болон эрх бүхий албан тушаалтнуудын тухай болон тэдгээрийн өөрчлөлтийн тухай мэдээлэл
 - б/ ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тухай мэдээлэл
 - в/ Нийт гаргасан хувьцааны 5 болон түнээс дээш хувийг эзэмшиж буй этгээд, хуулийн этгээдийн нэр, тэдгээрийн өөрчлөлт (тэдгээр этгээд нь компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол)
 - г/ Компанийн томоохон зээлдүүлэгчид харилцагчдын тухай мэдээлэл
 - д/ Компанийн хараат охин компанийн тухай мэдээлэл
 - е/ Компанийн халаасны хувьцааний тухай мэдээлэл
 - ё/ Компанийн нэр төв захиргааны байрлал өөрчлөгдсөн тухай мэдээлэл
 - ж/ Компанийн салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэл
 - з/ Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд гарсан өөрчлөлтийн тухай мэдээлэл
 - и/ Компанийн аудиторыг сонгон гэрээ байгуулсан, өөрчилсөн тухай
 - й/ Компанийн дүрмийн өөрчлөлтийн тухай
 - к/ Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хоргодуулах төслийг ТУЗ баталсан тухай
 - л/ Томоохон хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ юм уу хуульд заасан хувь нийлүүлэгчийн хурлаар баталсан тухай
 - м/ Компанийн үл хөдлөх хөрөнгийн 10-аас дээш хувийг худалдсан, барьцаалсан, ямар нэг хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл
 - н/ Төрийн болон орон нутгийн өмчлөлд байсан компанийн хувьцааны хяналтын багц хувьд шилжсэн
 - о/ Компанийг хуульд заасан хэлбэрээр өөрчлөн байгуулах төслийг ТУЗ баталсан
 - ү/ Нийтэд санал болгон шинээр нэмж гаргах үнэт цаасны төслийг ТУЗ болон хувь нийлүүлэгчийн хурлаар баталсан тухай мэдээлэл

- ө/ Компанийн санхүүгийн тайлан, төрийн зохицуулалтын байгууллагаас тогтоосон нэмэлт, тайлбар тодруулгын хамт
- п/ Компанийн үл хөдлөх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэсэн тухай тайлан
- р/ Компанийн борлуулалтын орлогын 10-аас дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, лицензийг худалдсан, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай
- с/ Компанийн бараа бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлд гарсан тмоохон өөрчлөлт, түүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл

4.5 Компаний үйл ажиллагааны жилийн тайлан дараах мэдээллүүдийг агуулсан байна. Үүнд:

- а/ Компанийн зорилго, үйл ажиллагааны стратеги
- б/ Санхүүгийн байдал ба үйл ажиллагааны үр дүн
- в/ Хувь нийлүүлэгчийн статус болон хувь нийлүүлэгчид эрх үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаарх статистик тоо баримт
- г/ Хөрөнгийн нэмэгдсэн байдал болон санхүүгийн жилд гарсан капиталжих зардал
- д/ Бизнесийн орчин ба эрсдлийн хүчин зүйлс
- е/ Компанийн удирдлагад ажиллагсдын талаарх мэдээлэл
- ё/ ТУЗ-ийн дарга, гишүүд, аудиторуд болон удирдлагуудын шагнал урамшуулал
- ж/ Хараат бус аудиторуд, рейтингийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын үнэлгээний тайлан
- з/ Мэдээллийг нээлттэй болгох талаар хууль зохицуулах байгууллагын журмын дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсэх, хэрэгжүүлээгүй бол хүлээсэн хариуцлага
- и/ Ирэх онд Компанийн засаглалын кодэксийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө

4.6 Хувь нийлүүлэгчдийн жилийн ээлжит хурлын өмнө дараах мэдээллийг хувь нийлүүлэгчдэд заавал танилцуулна. Үүнд:

- а/ Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан:
- б/ Жилийн санхүүгийн тайлан холбогдох тайлбар, тодруулга, аудитийн байгууллгын дүгнэлтийн хамт:
- в/ Ноогдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол үндэслэл:
- г/ Хянан шалгах зөвлөлийн тайлан:
- д/ Төлөөлөн удирдах болон хянан шалгах зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга:
- е/ Хэрвээ ээлжит хурлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх бол нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, үндэслэл, тайлбарын хамт, компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх бол өөрчлөн байгуулах хэлбэр, үндэслэл, өөрчлөн байгуулах журам, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам зэргийг тусгасан өөрчлөн байгуулах төсөл, бусад холбогдох бичиг баримт:
- ё/ Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бусад асуудлыг Хэлэлцэхэд хувьцаа эцэмшигчдэд ямар бичиг баримт танилцуулахыг компанийн “Мэдээлэлийн үйл ажилгааны журам”-д тусгасан байна.

- 4.7 Хууль, зохицуулах байгууллагын журам, энэүү кодексе болон компанийн дүрмээр тогтоосон мэдээллийг нээлттэй болгохоос гадна хувьцаа эзэмшигчдийн хүссэн мэдээллийг цаг тухайд нь саадгүй гаргаж өгнө.
- 4.8 Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой эзэмшиж байгаа этгээд нь компанийн нягтлан бодох бүртгэлийн болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэлтэй танилцах холбогдох мэдээллийг авах эрхтэй байна.
- 4.9 Хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр компанийн мэдээллийг гаргаж өгөх нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг байна. Мэдээлэл хүсэж байгаа хувьцаа эзэмшигч хүсэлтээ өөрийн болон эцэг эхийн нэр, хаяг, холбоо барих утас, эзэмшиж байгаа хувьцааны тоо төрөл, авахыг хүсэж буй мэдээлэл, мэдээлэл авах хэлбэр (бичлэн, бичгээр, электрон шуудангаар) зэргийг заасан байвал зохино.
- 4.10 Мэдээлэл авах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан мэдээллийг боломжит хэлбэрээр хүргүүлдэг журамлах нь зүйтэй. Хувьцаа эзэмшигчийн хүссэн мэдээлэл нь хууль тогтоомж болон компанийн дотоод бичиг баримтаар тогтоосон нээлттэй болгох мэдээллийн жагсаалтад багтаагүй бөгөөд компанийн бизнесийн нууцад хамаарахаар мэдээлэл бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг хүргүүлдэг байх шаардлагатай.

Тав. “Орхон жимс ногоо” хувьцаат компанийн дотоод хяналтын журам

Компанийн дотоод хяналтын бүтцийг хувь нийлүүлэгчдийн хурлаас томилогдон, түүнд ажлаа тайлагнан хянан шалгах зөвлөл, ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, гүйцэтгэх удирдлагын удирдлага дор ажиллах дотоод хяналтын албатай байхаар бүрдүүлэх нь зүйтэй. Харин Компанийн үйл ажиллагаан дахь явцын хяналтыг ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх аудитын хороог гүйцэтгэх удирдлагын удирдлага дор ажиллах дотоод хяналтын албаны хамт байгуулан эрх хэмжээ, ажлын хуваарийг компанийн дүрэмд нарийвчлан заах замаар ажиллана.

- 5.1 Компанийн дотоод хяналтын тогтолцоо нь Хянан шалгах зөвлөл /цаашид “ХШЗ” гэх/, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо /цаашид “АХ” гэх/, гүйцэтгэх удирдлагын удирдлага дор ажиллах дотоод хяналтын алба /цаашид “ДХА” гэх/-тай байна.
- 5.2 Хяналтын тогтолцоонд хамаарах нэгжүүд нь харилцан дэмжлэг үзүүлэхээс гадна аливаа хяналтын алба нь ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо болон ХШЗ-ийн хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа мэдээ мэдээллийг үнэн зөвөөр, шуурхай гаргаж өгөхөд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 5.3 ХШЗ-ийн үйл ажилгааны журмыг дүрэмд заахаас гадна АХ, ДХА-ны үйл ажиллагааны журмыг компанийн дүрэмд нарийвчлан тусгасан байна. Энэ нь тэдгээрийг чиг үүргээ хэрэгжүүлэх баталгааг бий болгохоос гадна үйл ажиллагааг дүгнэх, чиг үүргийн давхардлыг арилгахгүй байх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд ач холбогдолтой.
- 5.4 АХ-г ТУЗ-ийн гишүүдээр бүрдүүлж гишүүдийн тоог гурваас багагүй байхаар, гишүүдийн дийлэнхи олонх нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байхаар, ялангуяа АХ-ны дарга нь заавал хараат бус гишүүн байхаар компанийн дүрэмд заасан, АХ-ны гишүүдийг хувь нийлүүлэгчдийн хурлаар сонгодог байна.

- 5.5 АХ нь компанийн үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, төлөвлөгөөний биелэлт ямар байгаа, компанийн санхүүгийн удирдлага зохистой байгаа эсэх, компани нь санхүү, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтөлж байгаа эсэх, компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа зохистой байх эсэх, нууц болон дотоод мэдээлэл алдагдсан эсэх, түүнийг буруугаар ашигласан эсэх, хөндлөнгийн аудитыг зохих ёсоор гүйцэтгэсэн эсэх, ДХА-ны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх чиглэлээр тогтмол хяналтыг хэрэгжүүлдэг хараат бус нэгж байна.
- 5.6 АХ нь улиралд нэгээс доошгүй хуралдаж компанийн үйл ажиллагааны явцад хийсэн хяналтын дүнг заавал хэлэлцэх бөгөөд гишүүдийн олонх нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн боловсролтой, мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан туршлагатай байх нь зүйтэй.
- 5.7 АХ нь шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ХНХ-ыг зарлан хуралдуулах, түүгээр хэлэлцэх асуудлыг санал болгох, ДХА-ны үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, ДХА-ны хараат бус үйл ажиллагаанд хяналт тавих, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, зөрчил гаргасан бол түүнийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх эрхтэй байна.
- 5.8 АХ нь хөндлөнгийн аудитын үйл ажиллагаа зохих журмын дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавихаас гадна хөндлөнгийн аудиторoor ажиллахаар нэр дэвшигчдийн талаар урьдчилан хэлэлцэж ТУЗ-д оруулахаас гадна түүнтэй байгуулах гэрээний нөхцлийн талаар санал гаргах эрхтэй байна.
- 5.9 АХ-ны үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангахад шаардлагатай мэдээ мэдээлэл, баримтыг гүйцэтгэх удирдлага, түүнд хамаарах нэгжүүд эрх бүхий албан тушаалтан саадгүй гаргаж өгөх үүрэгтэй байхаас гадна мэдээллийг гаргаж өгөөгүй нөхцөлд хэрхэн шийдвэрлэх талаар компанийн дүрэмд тусгасан байна.
- 5.10 ДХА-ны үйл ажиллагааны зарчим журмыг ХШЗ, АХ-ны санал дүгнэлтэд үндэслэн, компанийн дүрэм, эсвэл компанийн дотоод журамд тусгасан байна. ДХА нь хяналт шалгалт явуулах талаар хүсэлт гомдлыг хүлээж авсанаас хойш хяналт явуулах эсэхийг 30 хоногийн дотор шуурхай шийдвэрлэдэг, шалгалтыг 90 хоногт багтаан дуусгавар болгодог байна.
- 5.11 ДХА-ны зорилго нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж стандарт, нөхцөл шаардлагын дагуу хийгдсэн эсэх, холбогдох эрх бүхий ажилтан үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн эсэх, төсвийн зарцуулалт, компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын ажиллагаанд аливаа алдаа дутагдал гарч буй эсэхэд хяналт тавихаас гадна ХШЗ, АХ-ны ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тэдгээрт болон гүйцэтгэх удирдлагад шаардлагатай заавар зөвлөмжийг хүргэж ажиллана.
- 5.12 ДХА нь шалгалтын дүнгээ тухай бүр, ХШЗ, АХ-д хүргүүлэхээс гадна шийдвэрийн биелэлтээ гүйцэтгэх удирдлага болон ХШЗ, АХ-д тайлагнадаг байна.
- 5.13 ДХА нь гүйцэтгэх удирдлага дор ажиллах нь хяналт шалгалтын гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудаас хараат бусаар гүйцэтгэх үүрэгтэй. Үүний тулд ДХА-тай байгуулах гэрээг ТУЗ, эсхүл АХ-ноос байгуулдаг байх нь зүйтэй.
- 5.14 Холбогдох төлөвлөгөөнд тусаагүй, томоохон хэмжээний хэлцэл, эсвэл сонирхлын зөрчил бүхий хэлцэл хамаарах магадлал бүхий, эсвэл компанийн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд байнга гүйцэтгэдэггүй гэрээ, хэлцэл, ажиллагаатай холбоотой

- асуудлыг гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд ДХА-аар заавал, шаардлагатай гэж үзвэл АХ, ХШЗ-өөр хянуулдаг байна. Үүнтэй холбоотой харилцааг компанийн дүрэмд нарийвчлан тусгасан байвал зохино.
- 5.15 ХШЗ, АХ-ны хурлын явцад тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн талаар тодорхой бичсэн байна. АХ нь хяналт шалгалтын үр дүнг тодорхой тусгасан тайланг жил бүр ТУЗ болон хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулж байна.
- 5.16 Хувьцаа эзэмшигчид ХШЗ, АХ, ДХА-ны хурлын тэмдэглэл, шалгалтын тайлан, дүгнэлттэй саадгүй танилцах эрхтэй байна.
- 5.17 ХШЗ, АХ, ДХА нь хөндлөнгийн аудитор, эсвэл хөндлөнгийн шинжээч /нягтлан бодогч ба хууль зэрэг/-ээс шаардлагатай туслалцаа, зөвлөгөө авч болно.
- 5.18 ХШЗ, АХ, ДХА нь өөрсдийн гишүүд, ажилтны танилцуулга, намтар, болон үйл ажиллагааныхаа жилийн тайланг тухайн жилд багтаан гаргаж дараа жилийн ээлжит хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулдаг байна.

Зургаа. “Орхон жимс ногоо” хувьцаат компанийн ногдол ашгийн бодлого

Ногдол ашгийн бодлого, ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах арга, механизм нь тодорхой, ойлгомжтой байх ёстой.

- 6.1 Хувьцаат компанийн хөрөнгө оруулалт татах чадвар нь түүний ногдол шиг хуваарилалт, ногдол ашгийн бодлоготой шууд холбоотой байдаг. Компанийн хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийхдээ тодорхой хэмжээний орлого олохоор төлөвлөдөг учраас “Ногдол ашгийн бодлого”-ыг ТУЗ-өөс боловсруулж, хувь нийлүүлэгчдийн хурлаар батлан мөрдүүлнэ. Уг бодлогод тухайн үеийн хувьцаа эзэмшигчид болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад компанийн ашиг хуваарилалтын бодлого, хэмжээ, хуваарилах арга хэлбэрийн талаар тодорхой тусгасан байвал зохино.
- 6.2 ТУЗ нь “Ногдол ашгийн бодлого”-ыг нийтийн хүртээл болгохоос гадна түүнтэй компанийн веб хуудас болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлсэн байна.
- 6.3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой.
- 6.4 Компани ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг ТУЗ хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар заавал танилцуулан хэлэлцүүлдэг байх шаардлагатай. Ялангуяа ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг заавал танилцуулна.
- 6.5 Хэдийгээр ногдол ашгийн үнэт цаас, биет эд хөрөнгөөр олгож болох ч ногдол ашгийг мөнгөн хөрөнгөөр олгох нь илүү зохимжтой. Энэ нь ногдол ашгийг тогтоосон хугацаанд олгосон эсэхэд хяналт тавих, ногдол ашиг олгох ажиллагааг аливаа маргаан, чирэгдэл, будлиангүйгээр зохион байгуулахад ач холбогдолтой.

- 6.6 Хуваарилж байгаа ногдол ашгийн хэмжээ нь компанийн бодит боломжинд үндэслэгдсэн, компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалт, болзошгүй эрсдлийн зардлыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилна.
- 6.7 Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна. Ногдол ашгийн хуваарилах хэлбэр, аргыг сонгохдоо хувьцаа эзэмшигчдийн оршин суугаа газар, ногдол ашгийг шуурхай хүлээн авах боломжийг харгалзана. Хувьцаа эзэмшигчид хүлээн зөвшөөрсөн, эсвэл компанийн оршин байх газраас өөр газар оршин суудаг бол ногдол ашгийг түүний банкны дансанд, эсвэл гуйвуулгаар, эсвэл бэлэн мөнгөөр гарт нь, эсвэл түүний үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар олгож болно.
- 6.8 Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой заасан, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусдаг байна. Ногдол ашиг хуваарилах хугацаа нь 60 хоногоос ихгүй байвал зохимжтой.
- 6.9 Ногдол ашгийг хугацаанд нь бүрэн олгоогүйгээс хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл учруулсан, хохироосон гүйцэтгэх удирдлагын ажилтанд хариуцлага хүлээлгээх журмыг тусгайлан компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээ, бусад дотоод журмуудад тусгасан байна. Ногдол ашгийг тогтоосон хугацаанд хуваарилах ажлыг хариуцлагагүй зохион байгуулсан тохиолдолд гүйцэтгэх удирдлагын урамшууллаас хасдаг, түүнд эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэдэг байж болно.